



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/549

Булган сум

Г Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Алтаргана 2024” олон улсын их наадмын хүрээнд зочид төлөөлөгчид ихээр цуглахтай холбогдуулан аймгийн төв халуун усны байрыг засварлах ажилд 20,000,000 (хорин сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Ажлын гүйцэтгэгчээр “Синамикс констракшн” ХХК-ийг сонгож гэрээ шууд байгуулан, ажлын гүйцэтгэлд холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Давааням)-д даалгасугай.

3. Гэрээнд заагдсан ажлыг холбогдох хууль, журмын дагуу тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэхийг “Синамикс констракшн” ХХК-ийн захирал (Г.Зулаа)-д үүрэг болгосугай.

4. Дээрх хөрөнгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн данс дахь Уулын баяжуулах “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын дэмжлэгээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6324010727